



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 4/950

Мандалговь

Зардал гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 , 14.2.5 дахь заалтууд, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны “Захиалагчийн хяналтын зардлын нэр төрөл батлах тухай” 85 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд нэг цэгээс хүргэх ухаалаг төхөөрөмж (киоск)-ийг худалдан авахад шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг техник хяналтын зардалаас гаргахыг Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-д зөвшөөрсүгэй.

2. Хяналтын зардлыг баталсан журмын дагуу төлөвлөж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100724